

## ЯПОН ДАХЬ МОНГОЛ УРАН ЗОХИОЛЫН НИЙГЭМЛЭГИЙН 2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ХУРАЛД

С.Байгалсайхан

*(Монгол Улсын Улаанбаатарын их сургуулийн захирал  
Япон дахь монгол уран зохиолын нийгэмлэгийн дэд захирал  
Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн  
Хэл бичгийн шинжлэх ухааны доктор, профессор)*

Та бүхний энэ өдрийн амрыг эрин мэндчилье. 2022 он: Монгол орны түүхэнд, тэмдэглэлт олон чухал үйл явдлын тэгш ой тохиож байна. Нэн түүрүүнээ Монголын их хаан эзэн Чингисийн мэндэлсний 860 жилийн түүхэн ой тохиож байгааг онцлон тэмдэглэх ёстой. Та бидний амьдран буй нийгмийн оршихуй, харилцаа холбоо, хүн хүнээ эрхэмлэн дээдлэх шударга үнэнч үзэл санааг жинхэнэ ёсоор нь батлан харуулсан их хааны үйл хэргийн агуу түүх өдгөө нийт хүн төрөлхтний сэтгэл сэтгэлгээний үнэт зүйл болсон байна.

Тэгвэл ХХ зууны Монголын түүхэнд онцгой байр эзлэх нэгэн чухал үйл явдал нь 1972 оны 2 дугаар сарын 24-ний өдөр байгуулагдсан Монгол Улс, Япон Улс хоорондын дипломат харилцаа, улмаар эл найрсаг харилцааг улам батжуулах, олон талаар хөгжүүлэх үүднээс Токио хотноо байгуулагдсан Япон дахь Монгол уран зохиолын нийгэмлэг билээ. Тиймээс Япон дахь Монгол уран зохиолын нийгэмлэгийн нийт гишүүдэдээ, 2022 оны хаврын ээлжит хуралд оролцож байгаа Монгол уран зохиол судлаач эрдэмтэн судлаач та бүхэнд Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жил, Япон дахь Монгол уран зохиолын нийгэмлэг байгуулагдсаны 50 жилийн баярын мэнд дэвшүүлье.

Монголын уран зохиол судлалд Японы Монгол уран зохиол судлаач эрдэмтэд чухал хувь нэмэр оруулсаар иржээ. Эхэн үедээ “Монголын нууц товчоо” тэргүүт хуучин бичгийн зохиол, түүхэн зохиол судлалаар амжилттай ажиллаж ирсэн бол, өнөө цаг үед судалгааны өмнөх уламжлалыг улам баяжуулсан ХХ зууны Монголын уран зохиол судлал, Д.Нацагдорж судлал, Ц.Дамдинсүрэн судлал, Ч.Лодойдамба судлал, Б.Явуухулан судлал, Д.Нямсүрэн судлал зэрэг чиглэлээр амжилттай ажиллахын сацуу орчин үеийн монголын олон зохиолчдын уран бүтээлийг япон хэлээр орчуулж, Японы уншигч судлаач олонд танилцуулсаар байгаа нь сайшаалтай.

Өнөөгийн дэлхий ертөнц олон томоохон сорилттой тулгарсаар байна. Цагийн аяс зөөлөрч, цөөнгүй хүчин зүйлийн эв зохицол, нөхцөл байдал бүрдэх аваас, бид Японы Монгол уран зохиолын нийгэмлэгийн 50 жилийн ойд зориулсан, хүндэтгэлийн эрдэм шинжилгээний хурлаа 2022 оны 8-р сард Улаанбаатар хотноо зохион байгуулахаар зорьж байгааг дуулгахад таатай байна.

Ингээд Японы Монгол уран зохиолын нийгэмлэгийн 2022 оны хаврын ээлжит хурлыг нээснийг мэдэгдээд, хуралд оролцогч та бүхэнд ажлын амжилт сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.